



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2005 оны 11 сарын 2 өдөр

Дугаар 216


Улаанбаатар хот

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 1/1986 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Илгээмжийн худалдаа" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2005 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс татан буулгасугай.

Хоёр. "Илгээмжийн худалдаа" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой үүссэн өр, авлагыг зохих журмын дагуу барагдуулах асуудлыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар / М. Цэрэндорж /-д хариуцуулан, тус байгууллагыг татан буулгах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч / Ц.Батбаяр /-д зөвшөөрсүгэй.



ДАРГА
ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

Валормаа Н.БОЛОРМАА

Ш.АЛТАНГЭРЭЛ

Я.Аюушжав Я.АЮУШЖАВ

Д.БААСАНСҮРЭН

С.Баярмөнх С.БАЯРМӨНХ

Т. БИЛЭГТ

Г.Мөнхбаяр Г.МӨНХБАЯР

С.ОТГОНБАТ

Б.Ундармаа Б.УНДАРМАА